

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 11 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/104/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Т.Эрдэнэтуяа Утас: 89275858 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага	18
5.3 Зөвлөмж	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР
СУМЫН 11 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Д.ОЮУНДАРЬ ТАНАА

**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025. 02. 25 № 116

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Хонгор сумын 11 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна. □

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолон тэмдэглэсэн хэсэг

Тайлант хугацаанд Боловсрол, шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалтаар 14,384.0 мянган төгрөгийн компьютер үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, тайлагнасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал 1,057,439.6 мянган төгрөг болж, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 60.0 хувиар өссөн байна.

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дархан Уул аймгийн Хонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 55 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 100 хувиар тайлагнасан байна. Мөн улирал бүр Боловсрол газарт ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	265,855,026.60	254,083,539.12
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	147,532,165.90	106,699,288.42
31211	Төрийн сангийн харилцах	147,532,165.90	106,699,288.42
33	АВЛАГА	-	-
332	Төлбөртэй үйлчилгээний авлага		
3351	Байгууллагаас авах авлага		
35	БАРАА МАТЕРИАЛ	118,322,860.70	147,384,250.70
351	Түүхий эд материал	4,100.00	900,000.00
3511	Тусгай зориулалттай материал	-	900,000.00
3513	Эм боох материал	4,100.00	-
354	Хангамжийн материал	118,318,760.70	146,484,250.70
35410	Бичиг хэргийн материал	444,700.00	-
35420	Аж ахуйн материал	-	406,500.00
3545	Барилгын засварын материал	11,751,158.00	12,719,158.00
3546	Хүнсний материал	2,841,315.00	6,285,805.00
35470	Бусад хангамжийн материал	103,281,587.70	127,072,787.70
36	НӨӨЦ БАРАА		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,082,670,974.18	2,051,725,547.85
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,082,670,974.18	2,051,725,547.85
392	Биет хөрөнгө	2,030,180,974.18	1,999,235,547.85
39201	Барилга, байгууламж орон сууц	1,800,863,898.00	1,800,863,898.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(177,577,856.49)	(215,031,003.33)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	375,120,153.22	312,872,271.32
39206	Хуримтлагдсан элэгдэл	(126,561,165.25)	(68,436,614.37)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	169,501,746.13	166,423,018.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	(41,765,694.88)	(30,353,524.20)
39214	Бусад үндсэн хөрөнгө	23,628,740.00	29,628,740.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(15,146,887.11)	(17,605,501.53)
39217	Ном	22,118,040.56	20,874,263.66
393	Биет бус хөрөнгө	52,490,000.00	52,490,000.00
39301	Программ хангамж	52,490,000.00	52,490,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,348,526,000.78	2,305,809,086.97
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,348,526,000.78	2,305,809,086.97
51	Засгийн газрын хувь оролцоо	2,348,526,000.78	2,305,809,086.97
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	825,612,346.61	825,612,346.61
51101	Өмч: - төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн	(626,127,678.81)	(621,114,508.78)
51210	Өмнөх үеийн үр дүн	(626,127,678.81)	(578,397,594.97)
51220	Тайлант үеийн үр дүн		(42,716,913.81)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,149,041,332.98	2,101,311,249.14
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,348,526,000.78	2,305,809,086.97




2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,471,458,745.50	1,556,579,164.12
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	357,839,345.50	66,192,664.12
120	Нийтлэг татварын бус орлого	357,839,345.50	66,192,664.12
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,072,648.00	1,459,100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	750,000.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,322,648.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	281,518,617.50	55,883,564.12
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	71,248,080.00	8,850,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,113,619,400.00	1,490,386,500.00
1,310.00	Улсын төвлөрсөн төсвөөс	961,765,800.00	1,277,632,900.00
131,001.00	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	961,765,800.00	1,277,632,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	151,853,600.00	212,753,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/	151,853,600.00	212,753,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,090,050,453.78	1,594,102,842.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,090,050,453.78	1,594,102,842.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,038,445,146.11	1,577,402,211.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	660,802,976.82	1,057,439,652.68
210101	Үндсэн цалин	489,237,031.26	668,835,428.76
210102	Нэмэгдэл	143,089,122.29	367,746,779.42
210104	Урамшуулал	28,476,823.27	20,857,444.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,608,258.31	130,021,208.48
210201	Тэтгэврийн даатгал	55,712,485.49	89,524,359.91
210202	Тэтгэмжийн даатгал	6,554,386.52	10,534,462.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,807,888.40	5,262,381.24
210204	Ажилгүйдлийн даатгал	1,223,866.67	4,914,744.53
210205	Эрүүл мэндийн даатгал	12,309,631.23	19,785,260.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	130,348,057.33	156,053,168.98
210301	Гэрэл, цахилгаан	11,262,857.33	14,149,968.98
210302	Түлш, халаалт	118,084,400.00	118,084,400.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,800.00	23,818,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,282,318.00	33,743,100.00
210401	Бичиг хэрэг	1,596,420.00	13,238,650.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	480,000.00	
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	4,205,898.00	3,256,450.00
210408	Бараа материал акталсны зардал		17,248,000.00
2105	Нормативт зардал	32,232,527.00	58,905,958.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	228,940.00	297,520.00



210502	Хоол, хүнс	32,003,587.00	58,608,438.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,242,000.00	16,325,050.00
210601	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	12,242,000.00	16,325,050.00
2107	Томилолт, зочны зардал	780,000.00	-
210702	Дотоод албан томилолт	780,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,964,879.15	13,803,318.32
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,511,168.00	1,159,045.92
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	5,453,711.15	11,644,272.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	71,184,129.50	111,110,754.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,459,500.00	15,091,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,370,973.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	56,353,656.50	96,019,754.85
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,605,307.67	16,700,631.02
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,099,765.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	32,912,265.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,187,500.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,505,542.67	16,700,631.02
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,505,542.67	16,700,631.02
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	381,408,291.72	(37,523,678.21)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		5,193,235.60
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН		(5,193,235.60)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	381,408,291.72	(42,716,913.81)




2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,118,692,048.00	1,491,845,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,072,648.00	1,459,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,072,648.00	1,459,100.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	5,072,648.00	1,459,100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	750,000.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,322,648.00	
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,113,619,400.00	1,490,386,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	961,765,800.00	1,277,632,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	961,765,800.00	1,277,632,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	151,853,600.00	212,753,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	151,853,600.00	212,753,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	994,039,148.61	1,516,203,846.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	994,039,148.61	1,516,203,846.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	949,745,156.61	1,483,882,382.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	660,802,976.82	1,057,439,652.68
210101	Үндсэн цалин	489,237,031.26	668,835,428.76
210102	Нэмэгдэл	143,089,122.29	367,746,779.42
210104	Урамшуулал	28,476,823.27	20,857,444.50
2102	Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,608,258.31	130,021,208.48
210201	Тэтгэврийн даатгалын	55,712,485.49	89,524,359.91
210202	Тэтгэмжийн даатгалын	6,554,386.52	10,534,462.36
210203	ҮОМШӨ-ий даатгалын	5,807,888.40	5,262,381.24
210204	Ажилгүйдлийн даатгалын	1,223,866.67	4,914,744.53
210205	Эрүүл мэндийн даатгалын	12,309,631.23	19,785,260.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	130,348,057.33	156,053,168.98
210301	Гэрэл, цахилгаан	11,262,857.33	14,149,968.98
210302	Түлш, халаалт	118,084,400.00	118,084,400.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,800.00	23,818,800.00
2105	Нормативт зардал	27,468,690.00	29,731,464.00
210502	Хоол, хүнс	27,468,690.00	29,731,464.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		

2106	Эд хогшил урсгал засвар	10,000,000.00	39,999,800.00
210601	Багаж техник хэрэгсэл		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	10,000,000.00	39,999,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж	6,003,711.15	15,588,418.32
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	550,000.00	1,459,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,453,711.15	14,129,318.32
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,513,463.00	55,048,670.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,142,490.00	45,462,170.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	8,370,973.00	9,586,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,293,992.00	32,321,464.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,293,992.00	32,321,464.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	37,106,492.00	32,321,464.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	7,187,500.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,505,542.67	16,700,631.02
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,505,542.67	16,700,631.02
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	124,652,899.39	(41,058,877.48)
4	Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн		
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн	42,872,150.00	-
	Дотоод эх үүсвэр	42,872,150.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	42,872,150.00	
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(42,872,150.00)	-
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	70,275,206.72	(41,058,877.48)
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	77,256,959.18	147,532,165.90
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	147,532,165.90	106,699,288.42
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		147,532,165.90
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		106,473,288.42



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 01-р сарын 01-нээрс үлдэгдэл	825,612,346.61	2,149,041,332.98	(1,007,535,970.53)	1,967,117,709.06
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	381,408,291.72	381,408,291.72
C08	2023 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	825,612,346.61	2,149,041,332.98	(626,127,678.81)	381,408,291.72
D01	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	47,730,083.84	47,730,083.84
D02	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	825,612,346.61	2,149,041,332.98	(578,397,594.97)	2,396,256,084.62
D03	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(47,730,083.84)		(47,730,083.84)
D04	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
D05	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
D06	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D07	Тайлант үеийн үр дүн			(42,716,913.81)	(42,716,913.81)
D08	2024 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	825,612,346.61	2,101,311,249.14	(621,114,508.78)	2,305,809,086.97



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,640,982,100.00	1,515,977,846.46	(125,004,253.54)	92.38
21	Урсгал зардлын дүн	1,640,982,100.00	1,501,593,846.46	(139,388,253.54)	91.51
210	Бараа үйлчилгээний зардал	1,600,785,000.00	1,469,272,382.46	(131,512,617.54)	91.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,122,146,100.00	1,057,439,652.68	(64,706,447.32)	94.23
210101	Үндсэн цалин	736,303,100.00	668,835,428.76	(67,467,671.24)	90.84
210102	Нэмэгдэл	370,849,800.00	367,746,779.42	(3,103,020.58)	99.16
210104	Урамшуулал	14,993,200.00	20,857,444.50	5,864,244.50	139.11
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	140,268,200.00	130,021,208.48	(10,246,991.52)	92.69
210201	Тэтгэврийн даатгал	95,382,400.00	89,524,359.91	(5,858,040.09)	93.86
210202	Тэтгэмжийн даатгал	11,221,400.00	10,534,462.36	(686,937.64)	93.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,610,700.00	5,262,381.24	(348,318.76)	93.79
210204	Ажилгүйдлийн даатгал	5,610,700.00	4,914,744.53	(695,955.47)	87.60
210205	ЭМД-ын хураамж	22,443,000.00	19,785,260.44	(2,657,739.56)	88.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	172,753,600.00	156,053,168.98	(16,700,431.02)	90.33
210301	Гэрэл, цахилгаан	28,800,000.00	14,149,968.98	(14,650,031.02)	49.13
210302	Түлш, халаалт	134,953,600.00	118,084,400.00	(16,869,200.00)	87.50
210303	Цэвэр, бохир ус	9,000,000.00	23,818,800.00	14,818,800.00	264.65
2105	Нормативт зардал	37,368,100.00	29,731,464.00	(7,636,636.00)	79.56
210502	Хоол хүнс	37,368,100.00	29,731,464.00	(7,636,636.00)	79.56
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,000,000.00	39,999,800.00	(200.00)	100.00
210604	Урсгал засвар	40,000,000.00	39,999,800.00	(200.00)	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	25,157,700.00	15,588,418.32	(9,569,281.68)	61.96
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,459,100.00	1,459,100.00	-	100.00
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	23,698,600.00	14,129,318.32	(9,569,281.68)	59.62
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63,091,300.00	40,438,670.00	(22,652,630.00)	64.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	53,504,800.00	30,852,170.00	(22,652,630.00)	57.66
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,586,500.00	9,586,500.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,197,100.00	32,321,464.00	(7,875,636.00)	80.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,197,100.00	32,321,464.00	(7,875,636.00)	80.41



213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	40,197,100.00	32,321,464.00		80.41
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	14,384,000.00		
	Дотоод эх үүсвэрээр		14,384,000.00		
	Тоног төхөөрөмж		14,384,000.00		
	Бусад хөрөнгө		14,384,000.00		
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,640,982,100.00	1,475,144,968.98		
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,428,228,500.00	1,277,632,900.00		89.46
132001	Орон нутгийн төсвөөс	212,753,600.00	196,052,968.98		92.15
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		1,459,100.00	(1,459,100.00)	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	77,256,959.18	147,532,165.90		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	147,532,165.90	106,699,288.42		
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
3	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
	АЖИЛЛАГСАДЫН ТОО	42.00	42.00	-	100.00
	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
	Гүйцэтгэх ажилтан	31.00	31.00	-	100.00
	Үйлчлэх ажилтан	10.00	10.00	-	100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 11 дүгээр сургууль нь "Хамтаараа хөгжиж хүүхэд нэг бүрийн зөв дадлыг дэмжигч сургууль" гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагааг явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ Үүнд:

- Эко хандлагатай
- Бие даан суралцадаг
- Эрүүл иргэн
- Зөв дадал
- Хөгжил
- Хамтаараа

Байгууллагын гадаад, дотоод орчин

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 11 дүгээр сургууль Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Хүүхдийн эрхийг

хамгаалах тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль Хүүхэд хамгааллын тухай хууль болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын “Аргачлал, зардлын норматив батлах тухай” 2022 оны А/23,27 дугаар тушаал зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд:

- “Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай” тогтоол Монгол улсын Засгийн газрын 2024 оны 53 дугаар тогтоолоор
- “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх” тогтоол Монгол улсын Засгийн газрын 2024 оны 25 дугаар тогтоолоор
- “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” тогтоол Монгол улсын Засгийн газрын 2024 оны 84 дүгээр тогтоолоор
- “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох” тогтоол Монгол улсын Засгийн газрын 2024 оны 82 тоот тогтоолоор
- “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш ажилтанд мөнгөн тэтгэмж олгох” журам Монгол улсын Засгийн газрын 2024 оны 104 тоот тогтоолоор
- Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамратсан 2024 оны А/85, А/34 тоот “Орон тооны хязгаарын жишиг норматив батлах тухай” тушаал

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан Уул аймгийн Хонгор сумын 11 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг газрын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар баталж, мөн оны 01 дүгээр сараас мөрдөж эхэлсэн бөгөөд өөрчлөлт ороогүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт, санхүүгийн программтай нийцсэн байна. Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх НББ-ийн журам”-ыг үндэслэн 2025 оноос Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулж мөрдөж ажиллана.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан Уул аймгийн Хонгор сумын 11 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 42,717.0 мянган төгрөгөөр буюу 1.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	147,532.20	106,699.30	(40,832.90)
Бараа материал	118,322.90	147,384.20	29,061.30
Үндсэн хөрөнгө	2,082,670.90	2,051,725.50	(30,945.40)
Нийт хөрөнгө	2,348,526.00	2,305,809.00	(42,717.00)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,348,526.00	2,305,809.00	(42,717.00)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,348,526.00	2,305,809.00	(42,717.00)

Тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлт 106,699.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 147,384.2 мянган төгрөг болж 29,061.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 129,185.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, Хонгор сумын ИТХ-ын 2024 оны 12 сарын 23-ны өдрийн 19 дугаар тогтоолоор 1,500.0 мянган төгрөгийн гэрэл хандиваар, байгалийн ухааны кабинетын тохижилт 5,000.0 мянган төгрөг, бидний дуу хоолой төслөөр хэрэгжсэн тоног төхөөрөмж 1,600.0 мянган төгрөг, мөн үндсэн хөрөнгийн данснаас 500,0 мянган төгрөгийн хивс 2ш, 200,0 мянган төгрөгийн молюворт, 50,0 мянган төгрөгийн рламшит бараа материалыг тус тус шилжүүлэн авч, 108,814.1 мянган төгрөгийн бараа материалыг урсгал үйл ажиллагаандаа зарцуулж, Орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оын 12 дугаар сарын 02-ны өдрийн А/33 тоот тушаалаар 160,0 мянган төгрөгийн сурагчийн сандалыг үндсэн хөрөнгө дансруу шилжүүлсэн зэргээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,051,725.5 мянган төгрөг болж 30,945.4 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр захиралын 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/38 тоот тушаалаар 14,384.0 мянган төгрөгийн үнэ бүхий 16 ш “ТабА9” тоног төхөөрөмж худалдан авч, Хонгор сумын ИТХ-ын 2024 оны 12 сарын 23-ны өдрийн 19 дугаар тогтоолоор 6,000.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө /сүүдрэвч-2ш/ хандиваар, мөн Бидний дуу хоолой төслөөр 10,400.0 мянган төгрөг тоног төхөөрөмж, локер шүүгээ төслөөр 19,800.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, Орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оын 12 дугаар сарын 02-ны өдрийн А/33 тоот тушаалаар 160,0 мянган төгрөгийн сурагчийн сандалыг шилжүүлэн авч, мөн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох Орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оны 12 дугаар

сарын 02-ны өдрийн А/35 тоот тушаалаар 46,525.2 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 18,001.4 мянган төгрөгийн тавилга эд хогшил нийт 64,526.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэлэн 10,727.7 мянган төгрөгөөр үнэлж, 3,949.4 мянган төгрөгийн ном, 4,846.3 мянган төгрөгийн тавилга эд хогшил үнэ төлбөргүй хүлээн авч, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2024 оны 12 сарын 31-ны өдрийн 01-А/333 дугаар захирамжаар 65,001.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан зэргээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,305,809.1 мянган төгрөг болж 349,420.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 1,073,537.3 мянган төгрөгөөр тооцож, санхүүжих эх үүсвэрийг улсын төсвөөс бүрдүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Дээд шатны төсвийн захирагч төсвийн саналыг нийт 148,215.7 мянган төгрөгөөр бууруулж 925,321.6 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхдээ улсын төсвөөс 1,428,228.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 212,753.6 мянган төгрөг нийт 1,640,982.1 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 212,753.6 мянган төгрөг, улсын төсвөөс 1,277,632.9 мянган төгрөг, урьд оны үлдэгдэл 147,532.2 мянган төгрөг, номны түрээсийн орлого 1,459.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос, 1,515,977.8 мянган төгрөгийг зарцуулж, 16,700.6 мянган төгрөгийг төвлөрүүлж, 106,699.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,515,977.8 мянган төгрөг буюу 92.38 хувьтай байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөв-лөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Бие-лэлт
		Код	Нэр				
1	71802	80233	Хүүхэд хамгаалал	2,667,000.00	2,666,500.00	500.00	99.98%
2		80226	Байр ашиглалтын үйлчилгээ	2,513,800.00	2,513,800.00	0.00	100.00 %
3		80312	Сургалт семинар	2,891,300.00	425,000.00	2,466,300.00	14.70%
4		81605	Эрүүл мэндийг дэмжих	3,095,200.00	2,395,000.00	700,200.00	77.38%
5		81801	үдийн цай хөтөлбөр	40,197,100.00	32,321,464.00	7,875,636.00	80.41%
6		81806	Дотуур байрны үйлчилгээ	145,863,400.00	104,316,978.40	41,546,421.60	71.52%
7		81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	14,845,600.00	14,384,000.00	461,600.00	96.89%

8	81823	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	9,059,800.00	6,899,900.00	2,159,900.00	76.16%
9	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	14,111,800.00	13,971,650.00	140,150.00	99.01%
10	81848	Сурах бичгийн түрээс	1,459,100.00	1,459,100.00	0.00	100.00 %
11	81875	Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	4,283,200.00	2,485,045.92	1,798,154.08	58.02%
12	81834	Боловсролын стандарт, сургалты	1,185,483,700.00	1,136,086,439.16	49,397,260.84	95.83%
13	80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	212,753,600.00	196,052,968.98	16,700,631.02	92.15%
14	80217	Мэдээлэл технологийн үйлчилгээ	1,757,500.00		1,757,500.00	0.00%
		Нийт дүн	1,640,982,100.00	1,515,977,846.46	125,004,253.54	92.38%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Тайлант онд тус сургууль нь удирдах 1 ажилтан, гүйцэтгэх 31 ажилтан, үйлчлэх 10 ажилтан буюу нийт 42 ажилтантайгаар ажиллаж, 210801- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 1,459.1 мянган төгрөг, 210901- Бараа үйлчилгээний бусад зардалд 45,462.2 мянган төгрөгийг зарцуулж, худалдан авах ажиллагаатай холбоотой 69,914.7 мянган төгрөгийн ажил, үйлчилгээ төлөвлөж худалдан авах ажиллагааг зохион байгуулж нэг оролцогч шалгарсан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан Уул аймгийн Хонгор сумын 11 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн ахмадын сан болон шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Ч.Мөнхбаяр гүйцэтгэж анхан шатны хяналтыг чанарын менежер Т.Эрдэнэтуяа, захирал Ч.Цэрэннадмид, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан Уул аймгийн Хонгор сумын 11 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг ЦЭСБ-Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,090,050.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 10,900.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Дархан Уул аймгийн Хонгор сумын 11 дүгээр сургуулийн 2024 оны төсвийг батлахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 5 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээнээс 4 мэдээг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны системд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах зөвлөмж хүргүүлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу "Ахмадын сан" байгуулж, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллах журам"-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд илрүүлсэн алдаа, зөрчил гараагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчлийг арилгах 1,270.9 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоосныг 100 хувь биелүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	3	1,270.9	3	1,270.9	100
Нийт дүн	3	1,270.9	3	1,270.9	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Боловсролын ерөнхий газрын 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр баталсан 1,073,537.3 мянган төгрөгийн төсвийн хуваарийг 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 204,095.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр 23,444.4 мянган төгрөг төвлөрсөн тул харилцах дансны үлдэгдэл өсөж төсвийн гүйцэтгэл 92.8 хувьтай гарсан байна. Иймд төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудлыг дараагийн шатны аудитаар шалгаж, шийдэл гаргах нь зүйтэй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,412.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэн тул зөрчлийг таслан зогсоох 2,316.0 мянган төгрөгийн албан шаардлага, 2,096.0 мянган төгрөгийн нөхөн төлүүлэх төлбөрийн акт, цаашид хэрэгжүүлэн ажиллах 2 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Илрүүлэлт Тушаал шийдвэргүйгээр ур чадварын нэмэгдэл 1,467.6 мянган төгрөг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 1996 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 63/104 дүгээр тушаалын 7 дахь заалтад “Ур чадварын нэмэгдлийг ажилтнуудын цалинг нэмэх, амьдрал ахуйг харгалзах зэргээр хавтгайруулан олгохыг хориглоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.1.2 Илрүүлэлт Тус сургуулийн бичиг хэрэг 2024 оны 10 дугаар сард тушаал шийдвэргүйгээр цалингийн зөрүү гэж 628.4 мянган төгрөг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.2 Албан шаардлага

5.2.1.Илрүүлэлт: Байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Өөрчлөлтгүй” дүгнэлт авсан шалтгаанаар Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын А/141 дүгээр тушаалыг баримтлан сургуулийн захирал Д.Оюундарь үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлж, 2,316.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь хэсэгтэй нийцээгүй тул албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Санхүүгийн үйл ажиллагаанд холбогдох зөвлөмж өгөөгүй болно.

Тайлангийн 4.4.1 дэх хэсэгт дурьдсан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, 4.4.2 дахь хэсэгт дурдсан Ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой тус тус зөрчилд өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	1	2,316.0			1	2,316.0						
1	1	1,467.6	1	1,467.6								
1	1	628.4	1	628.4								
Дүн	3	4,412.0	2	2,096.0	1	2,316.0	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны цахим системд, байгууллагын батлагдсан төсөв мэдээлэлийг хугацаа хоцроож байршуулсан байна.	1	-					1	-
Тус цэцэрлэгийн Ахмадын тухай хуулийн 14.7 заасан "Төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" заалтыг зөрчиж ахмадын сан байгуулаагүй байна.	1						1	
Дүн	2	-					2	-